



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/ЧС1

Улаанбаатар хот

### Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эцэг эхээс хандивласан 3,035,000.0 (гурван сая гучин таван мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль (Б.Чойдорж)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль (Б.Чойдорж)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В. Оюумаа* В.ОЮУМАА





Нийслэлийн өмчийн харилцааны газрын  
 даргын 2025 оны 10 дүгээр сарын 19-ны  
 өдрийн АУС дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 14-р сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалта д авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр	
								нэгжийн үнэ	нийт дүн			
1	Ус цэвэршүүлэгч	waco		2025	шинэ	ш	1	750,000.00	750,000.00	Эцэг эхийн хандив	хандив	
2	Ус цэвэршүүлэгч	kisen	15 литр	2025	шинэ	ш	1	300,000.00	300,000.00			
3	Ус цэвэршүүлэгч	hyundai	15 литр	2025	шинэ	ш	1	250,000.00	250,000.00			
4	Ус цэвэршүүлэгч	hyundai		2025	шинэ	ш	1	300,000.00	300,000.00			
5	Ус цэвэршүүлэгч	hyundai		2025	шинэ	ш	1	250,000.00	250,000.00			
6	Ус цэвэршүүлэгч	elko		2025	шинэ	ш	1	120,000.00	120,000.00			
7	Ус цэвэршүүлэгч	kisen		2025	шинэ	ш	1	150,000.00	150,000.00			
8	Ус цэвэршүүлэгч	hyundai	15 литр	2025	шинэ	ш	1	250,000.00	250,000.00			
9	Ус цэвэршүүлэгч	luogle		2025	шинэ	ш	1	250,000.00	250,000.00			
10	Ус цэвэршүүлэгч	elko		2025	шинэ	ш	1	415,000.00	415,000.00			
									3,035,000.00			
										3,035,000.00		
Тоног төхөөрөмжийн дүн												
НИЙТ ДҮН												